



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:ӨВА-2022/6/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц,Чанцалдиймаа

Утас: 99710673 Цахим хаяг: chantsal1227 @ yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	8
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Дотоод хяналт.....	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
4.4 Материаллаг байдал.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Залруулсан алдаа.....	12
8.2 Төлбөрийн акт.....	12
8.3 Албан шаардлага.....	12
8.4 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХУЖИРТ СУМЫН ЭРДЭС БАЯЛАГ
ОНӨАТУГ-ЫН ДАРГА Ж ШИЖЭЭ ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Г.Гэндангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173
Утас/Факс: (076) 7032 3253
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Танай _____ № _____
_____ ны № _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хужирт сумын Эрдэс баялаг ОНӨАТУГ-аар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хужирт сумын Эрдэс баялаг ОНӨАТУГ-аар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0
1.1	Эргэлтийн хөрөнгө	22,910.5	18,892.2
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	22,293.0	18,289.2
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	187.5	173.0
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	430.0	430.0
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	22,910.5	18,892.2
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	121,672.1	67,256.1
1.2.2	Биет бус хөрөнгө	50,000.0	47,916.7
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	171,672.1	115,172.8
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	194,582.6	134,065.0
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		354.4
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		354.4
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		354.4
	ЭЗДИЙН ӨМЧ	194,582.6	133,710.6
2.3	Өмч	202,579.2	202,579.2
2.3.1	-төрийн	202,579.2	202,579.2
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.0	0.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-7,996.6	-68,868.6
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	194,582.6	133,710.6
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	194,582.6	134,065.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	68,250.0	62,192.0
2	Борлуулалтын өртөг	0.0	0.0
3	Нийт ашиг (алдагдал)	68,250.0	62,192.0
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	86,358.3	80,348.0
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	2,260.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-15,597.7	-18,156.0
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-15,597.7	-18,156.0
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-15,597.7	-18,156.0
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-15,597.7	-18,156.0
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримт- лагдсан ашиг	Нийт дүн
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	21,965.3	21,965.3

1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	152,579.2	0.0	-14,364.2	138,215.0
2	Залруулсан үлдэгдэл	152,579.2	0.0	7,601.1	160,180.3
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-15,597.7	-15,597.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого				
5	Өмчид гарсан өөрчлөлт	50,000.0	0.0	0.0	50,000.0
6	Зарласан ногдол ашиг				
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	202,579.2	0.0	-7,996.6	194,582.6
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-42,716.0	-42,716.0
2	Залруулсан үлдэгдэл	202,579.2	0.0	-50,712.6	151,866.6
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-18,156.0	-18,156.0
4	Бусад дэлгэрэнгүй орлого				
5	Өмчид гарсан өөрчлөлт				
6	Зарласан ногдол ашиг				
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	202,579.2	0.0	-68,868.6	133,710.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	69,010.8	62,192.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	250.6	200.0
1.1.3	Даатгалы нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	68,250.0	61992.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	510.2	0.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	68,683.1	66,195.8
1.2.1	Ажиллагчдад төлсөн	34,060.1	31,489.4
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,154.4	10,640.0

1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,973.1	14,393.4
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,897.9	8,201.2
1.2.6	Хүүний төл өрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,089.3	0.0
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	508.3	1,471.8
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	327.7	-4,003.8
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛА ААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
2.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэ төлсөн		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
4	Валютын ханшийн зөрүү	0 0	0.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	327.7	-4,003.8
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	21,965.3	22,293.0
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	22,293.0	18,289.2

3. Аудитын тайлан

3.1 Байгууллагын үйл ажилагаа

Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГазрын зорилго нь: Улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бий болсон нийтийн эзэмшлийн барилга байгууламж, эд хөрөнгө

тохижилтын ажлыг хүлээн авах түүнтэй холбогдон үүсэх эрх, хариуцлагыг хүлээж, зам талбай, авто зогсоол, түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмж, тохижилтын бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцах, түүнчлэн эмчилгээний зориулалттай рашаан нөөц ашиглалтыг зохицуулах, нөхөн сэргээх, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, нохой устгалын ажлыг хариуцан ажиллахад оршино гэсэн чиглэлээр компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд улсын төсөвт үйлдвэрийн газар статустай байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хужирт сумын Эрдэс баялаг ОНӨАТҮГазар нь Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 01-р сарын 25-ны 07 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд Улсын төсөвт үйлдвэрийн газар гэж бүртгэсэн боловч 1 гишүүнтэй хөрөнгийн хэмжээ 1000.0 мянган төгрөг гэж бүртгэсэн байна. Мөн 2020 оны 09-р сарын 17-ны 58 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн, дүрмийг баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж, мөн хуулийн 5 дүгээр зүйлд “4/ улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан; ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хужирт сумын Эрдэс баялаг ОНӨАТҮГазрын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,293.0	18,289.2	-4,003.8
БХХО			0.0

Авлага	187.5	173.0	-14.5
Урьдчилгаа			0.0
Бараа материал	430.0	430.0	0.0
Үндсэн хөрөнгө	121,672.1	67,256.1	-54,416.0
Биет бус хөрөнгө	50,000.0	47,916.7	-2,083.3
Нийт хөрөнгийн дүн	194,582.6	134,065.0	-60,517.6
Өр төлбөрийн дүн			0.0
Богино хугацаат өглөг		354.4	354.4
Урт хугацаат өглөг			0.0
Эздийн өмч	194,582.6	133,710.6	-60,872.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	194582.6	134065.0	-60,517.6

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл байхгүй байна. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 18.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд бүгд 0.2 сая төгрөгөөс ХХОАТ-ын авлага 0.2 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 0.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны үлдэгдэл хэвээр байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өсөж буураагүй байна. Биет бус хөрөнгөнд 50.0 сая төгрөгөөр газар эзэмших, ашиглах эрхийг шинээр үнэлж бүртгэснээс тайлант онд 2.1 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 0.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Энэ нь ХХОАТ-ын өглөгтэй гарсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 6.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГазар нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГазрын 2021 оны төсвийг Хужирт сумын ИТХ-ын 2020 оны 12-р сарын 18-ны өдрийн 8/2/6 дугаар тогтоолоор 52.0 сая төгрөгөөр 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Мөн Хужирт сумын ИТХ-ын 2021 оны 09-р сарын 15-ны өдрийн 8/4/1 дугаар тогтоолоор тодотгол хийж 10.0 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилт олгосон байна.

Тайлант оны нийт орлогыг орон нутгийн төсвөөс 62.0 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 80.3 сая төгрөг зардал гаргаж, 18.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Ж.Шижээд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Чанцалдиймаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02-р сарын 28 -ны өдрийн 05 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Эрдэс баялаг УТҮГ-аар нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Мөн дотоод хяналтын нэгж байгуулаагүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 80.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 0.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд 148 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас 134 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Нийт мэдээллийн 91.9 хувийг хугацаандаа 8.1 хувийг хугацаа хоцроосон байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) хэсэгт:

НИК ХХК 15.1 сая төгрөгийн шатахуун худалдан авалтыг өссөн дүнгээр байршуулахаас 10.9 сая төгрөг буюу 4.2 сая төгрөгөөр дутуу байршуулсан. Мөн санхүүжилт 62.0 сая төгрөгийг өссөн дүнгээр тус тус шилэн дансанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд санхүүжилтийг шилэн дансанд байршуулаагүй 65.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, Нягтлан бодогч нь нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн 1 зөрчилд 1 зөвлөмж өгснөөс албан шаардлагын биелэлт хангалтгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	65100.0					
Зөвлөмж	1	0					
Нийт дүн	2	65100.0					

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө зарцуулах тушаалуудын үндэслэл, тэдгээрийн хүчин төгөлдөр байдалд болон санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд онцгой анхаарах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 66.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж байна

8.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

8.3 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) хэсэгт: НИК ХХК 15.1 сая төгрөгийн шатахуун худалдан авалтыг өссөн дүнгээр байршуулах байсныг алдаатай 10.9 сая төгрөг гэж 4.2 сая төгрөгөөр дутуу байршуулсан. Мөн санхүүжилт 62.0 сая төгрөгийг өссөн дүнгээр тус тус шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.5,4.5-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Мөн дотоод хяналтын нэгж байгуулаагүй, нягтлан бодогч нь нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн 1 зөрчилд 1 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Энэ нь байгууллагын дотоод хяналт сул байгааг харуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19-р зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг; 18.2.-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

8.4 Зөвлөмж

Байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГ	1	0	0	0	0	0	1	0	0	0
Дүн											
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хужирт сумын Эрдэс баялаг УТҮГ	1	66.2					1	66.2		
Дүн		1	66.2					1	66.2		
Нийт дүн		2	66.2					2	66.2		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.ЧАНЦАЛДИЙМАА

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР